

# ИРГЭДЭЭС ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



2024 оны 07 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

## Нэг. Иргэдээс цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар


Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын удирдах албан тушаалтанд 2024 оны эхний хагас жилд иргэдээс 11234 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 827 нэгжээр буюу 6.9 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 261 буюу 2.3 хувь нь санал, 10714 буюу 95.4 хувь нь өргөдөл, 259 буюу 2.3 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 746 буюу 6.6 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 202 буюу 1.8 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1563 буюу 13.9 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2239 буюу 19.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 375 буюу 3.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 6109 буюу 54.4 хувь нь бусад / Хувийн хэргээс баримт бичиг, дипломын хавсралт авах, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой/ өргөдөл, гомдол байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11058 буюу 98.4 хувийг шийдвэрлэж, 176 буюу 1.6 хувь нь ажиллагаанд байна.



**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**


2024 оны эхний хагас жилд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, алба хаагчдаас 511 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 204 нэгжээр буюу 66.4 хувиар өсчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 390 буюу 76.3 хувь нь өргөдөл, 70 буюу 13.7 хувь нь гомдол, 51 буюу 10.0 хувь нь санал байна.



**Иргэдээс цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг үтгээр нь авч үзвэл:**

33 буюу 6.5 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 30 буюу 5.9 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 36 буюу 7.0 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 13 буюу 2.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 52 буюу 10.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 347 буюу 68.0 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.






**Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн талаар**

2024 оны эхний хагас жилд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 2955 санал, өргөдөл, гомдол, талархал, ирүүлсний 153 буюу 5.2 хувь нь санал, 2029 буюу 68.7 хувь нь гомдол, 364 буюу 12.3 хувь өргөдөл, 409 буюу 13.8 хувь нь талархал байна.


Нийт санал хүсэлт, өргөдөл, гомдол, талархлын 169 буюу 5.7 хувь нь цагдаагийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн, 627 буюу 21.2 хувь нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, 333 буюу 11.3 хувь нь зөрчлийн шинжтэй, 195 буюу 6.6 хувь нь мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой, 275 буюу 9.3 хувь нь тээврийн хэрэгслийн торгуультай холбоотой, 1356 буюу 45.9 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэлийн 2586 буюу 87.5 хувийг шийдвэрлэж, 369 буюу 12.5 хувийг холбогдох алба, нэгжид судалж байна.

**Дөрөв. Иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн нийт 1321 өргөдөл, гомдолд 1496 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 1321 буюу 88.3 хувийг офицер, 174 буюу 11.6 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 67 буюу 5.0 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 270 буюу 20.4 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 73 буюу 5.5 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 56 буюу 4.2 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 8 буюу 0.6 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 263 буюу 20.0 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 34 буюу 2.5 хувь нь бусдын эрх чөлөөнд халдсан, 214 буюу 16.1 хувь нь ажлын хариуцлага алдсан, 14 буюу 1.0 хувь нь архидан согтуурсан, 2 буюу 0.1 хувь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 249 буюу 18.8 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, 2 буюу 0.1 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу олгосон, 69 буюу 5.2 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.



Нийт хүлээн авсан **1321** өргөдөл, гомдлоос **1210 буюу 91.5** хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, **111 буюу 8.5** хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл: Холбогдсон алба хаагчдын 20 буюу 1.3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 126 буюу 8.4 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 1160 буюу 77.5 хувьд нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 148 буюу 9.8 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр хааж шийдвэрлэсэн байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС